



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 275

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Соёл, Урлагийн Их Сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 12,000,000.00 (арван хоёр сая) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн салбар Дорнод бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн хүрээлэнд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ням-Очир, Соёл, Урлагийн Их Сургуулийн захирал Э.Сонинтогос, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн салбар Дорнод бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн хүрээлэнгийн захирал Ш.Насанбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002001



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2018 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн
875 дугаар тогтоолын хавсралт

Соёл, Урлагийн Их Сургуулийн балансаас Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн салбар
Дорнод бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн хүрээлэнгийн балансад шилжүүлэх
эд хөрөнгийн жагсаалт

Д/д	Автомашини марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөл
						нэг бүрийн үнэ	нийт үнэ		
(төгрөг)									
1	СсангЁнг Истана, 60-60УБЕ, микробус, арал:КРАФВФС812Р147746, хөдөлгүүр:6620113501	ш	1	2/10/2010	120000	12,000,000.00	12,000,000.00	12,000,000.00	-
Нийт дүн						12,000,000.00	12,000,000.00	12,000,000.00	0
(арван хоёр сая)									